

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс



2014 оны 4-р улирал

ACI Mongolia, Financial market association

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс түүхэн доод түвшинд хүрлээ.

Оны эцэс гэхэд 174 байсан ХХИ 2014 оны 4-р улиралд 81 болж буурлаа. Энэхүү уналт нь Монголын эдийн засагт итгэх иргэдийн итгэл туйлдаа хүрээд буйг харуулж байна.



Монголын эдийн засагт итгэх иргэдийн итгэл буурсаар түүхэн доод түвшинд хүрлээ...


ХХИ индексийн дэд индикаторууд болох өнөөгийн нөхцөл байдлын индикатор 39.70 болж, ирээдүйн нөхцөл байдлын индикатор 45.77 болж тус тус буурлаа.

- Өнөөгийн нөхцөл байдлын индикатор – 39.70
- Ирээдүйн нөхцөл байдлын индикатор – 45.77

Дэд индикаторуудын хувьд өнөөгийн нөхцөл байдлын индикатор огцом уналтыг үзүүлж, мөн адил түүхэн доод түвшинд хүрээд байна. Харин ирээдүйн нөхцөл байдлын индикатор харьцангуй бага бууралттай байгаа юм. Энэ нь Монгол Улсын иргэд ирэх оны эдийн засгийн нөхцөл байдал сайжирна гэдэгт итгэсээр байгааг харуулж байна.

2014 оны эцэст эдийн засгийн өсөлт 6.7 хувьтай гарсан. Мөн ам.долларын ханш өссөөр 1982 хүрсэн гэх сөрөг үзүүлэлтүүдтэй байлаа. Ирээдүйгээ сайнаар төсөөлөх иргэд төдийлөн буураагүй нь эерэг хүлээлт байсаар байгааг харуулж байна. Хэрвээ ирэх улиралд эдийн засгийн нөхцөл байдал энэ хэвээр үргэлжилбэл ХХИ дахин буурах магадлалтай байна.

График 1 | Хэрэглэгчийн хүлээлтийн индекс




Эх сурвалж: Монголын санхүүгийн зах зээлийн холбоо




Ирээдүйгээ сөргөөр хүлээдэг иргэдийн тоо 6 нэгж хувиар өссөн байна.

ХХИ-ийн үндсэн үзүүлэлтээс гадна нэмэлт асуултууд тус судалгаанд орж, онцлог дүнг түүвэрлэн хүргэдэг билээ. Энэ улирлын хувьд зөвхөн эдийн засаг бус ирээдүйгээ сөргөөр төсөөлөх ба өөрчлөлт гарахгүй гэж бодох иргэдийн тоо нэмэгдээд байна.

Зураг 2 | Та өөрийн амьдралын ирээдүйн 1 жилийг ямар байдлаар харж байна?



Зураг 3 | Танай гэр бүлийн өдөр тутмын хэрэглэдэг бараа бүтээгдэхүүний үнэ ирэх 1 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?




Орон сууцны үнэ буурах хүлээлттэй иргэдийн тоо 9 нэгж хувиар өссөн байна.

Дараагийн онцлох дүн бол инфляцийн хүлээлт юм. Инфляцийг буурах хүлээлттэй байгаа иргэдийн тоо өмнөх улирлаас өссөн үр дүнг үзүүлээ. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 51 хувь нь ирэх нэг жилийн хугацаанд инфляци өснө гэсэн хүлээлттэй байхад 21 хувь нь буурна хэмээн хүлээж байгаа ажээ. Харин үлдсэн 28 хувь нь өөрчлөлт гарахгүй болов уу хэмээн таамаглаж байна. Өмнөх улиралтай харьцуулахад, инфляци өснө хэмээн хүлээж байгаа иргэд 1 нэгж хувиар, буурна хэмээн хүлээж байгаа иргэд 2 нэгж хувиар тус тус өслөө.

Энэ улирлын судалгааны эцсийн онцлох дүн нь орон сууцны үнийн хүлээлтийн дүн юм. Орон сууцны үнэ өмнөх саруудад буурсаар байгаа ба нийлүүлэлт хангалттай хийгдэж байгаа учир иргэдийн орон сууцны үнэ буурах хүлээлт өссөөр байна.

Зураг 4 | Орон сууцны үнэ ирэх жилд хэрхэн өөрчдөгдөх вэ?



Товч танилцуулга

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс

Хэрэглэгчийн хүлээлтийн индекс (ХХИ) нь дэлхийн олонх хөгжингүй орнуудад тухайн улс өөрийн иргэдийн хэрэглээндээ зарцуулж байгаа зардлын ирээдүйн хандлагыг тодорхойлох зорилгоор тооцдог өндөр ач холбогдол бүхий эдийн засгийн индикатор юм. Аливаа нэгэн улсын эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлохын тулд тэргүүлэгч буюу эдийн засгийн ирээдүйн төлөв байдлыг харуулдаг индикатор болон улс орны эдийн засгийн тухайн үеийн төлөвийг харуулдаг индикаторыг тооцож үзэх шаардлагатай болдог. ХХИ нь эдийн засгийн ирээдүйн төлөв байдлыг урьдчилан харуулдаг тэргүүлэгч индикатор бөгөөд зах зээлийн эдийн засагтай орнуудын хувьд тухайн улсын эдийн засгийн ирээдүйн хандлага нь эдийн засаг дахь хэрэглэгчдийн үйл хөдлөл, эдийн засгийн ирээдүйн төлөв байдлын талаархи хүлээлт, тэдгээрийн хэрэглээндээ зарцуулж байгаа зардлын хэмжээ зэргээс голчлон хамаардаг болсон учраас дэлхийн олон улс орон хэрэглэгчдийнхээ үйл хөдлөл, хүлээлт дээр тулгуурласан энэ индексийг тооцож, шийдвэр гаргалтандаа чухал үзүүлэлт болгон ашигласаар ирсэн байна.

ХХИ нь зөвхөн бодлого боловсруулагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын хувьд бус бизнес эрхлэгчдийн хувьд ч ирээдүйн төлөвлөлт, шийдвэр гаргалтандаа ашиглаж болох мэдээллийн чухал эх үүсвэр болдог ороо ихээхэн ач холбогдолтой юм. Ийм учраас дэлхийн хөгжингүй орнуудад энэ индекс ихээхэн ач холбогдол өгч, тогтмол тооцооор ирсэн. Тухайлбал, Америкийн Conference Board, Германы ZEW зэрэг байгууллагууд энэ индексийг тогтмол тооцдог бөгөөд индекс нь эдийн засгийн ирээдүйн чиг хандлагыг гайхалтай зөв харуулж чаддаг нь батлагдсан байна.

Манай улсын хувьд анх 2009 оноос эхлэн Санхүүгийн Зах Зээлийн Холбоо болон Нээлттэй Нийгэм Форум уг индексийг Улаанбаатар хотын хэмжээнд тус тусдаа тооцож байсан бөгөөд 2010 оны нэгдүгээр улирлаас дээрхи хоёр байгууллага хамтран энэхүү индексийг тооцож байна.

ХХИ-ийг Монгол улсын эдийн засгийн бүтцэд тохируулан улирал тутамд нэг удаа, нийт 1000 хүнээс санал асуулга авах замаар тооцож байна. Санал асуулгад оролцогчийг Монгол улсын нийгэм, эдийн засгийн бүтцийг төлөөлөхүйц байдлаар статистик түүврийн аргаар сонгодог. Хэрэглэгчийн хүлээлтийн индексийн санал асуулга нь өөртөө Хэрэглэгчийн хүлээлтийн индекс болон индикаторыг агуулдаг. Индекс нь хэрэглэгчдийн хүлээлт өмнөх үетэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулдаг бол индикатор нь хэрэглэгчдийн эдийн засгийн талаарх ерөнхий хүлээлт эерэг эсвэл сөрөг байгаа эсэхийг харуулдаг ач холбогдолтой юм.